

Хөгжлийн хэлэлцүүлэг 1. Монгол Улс болон 2015 оноос хойшхи хөгжлийн зорилт

Товч Тайлан

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс 2012-13 онд зохион байгуулж буй “Хөгжлийн хэлэлцүүлэг” цувралын эхний хэлэлцүүлэг болох “2015 оноос хойшхи хөгжлийн зорилт” хэлэлцүүлэг энэ оны 12 дугаар сарын 5-нд амжилттай зохион байгуулагдлаа. Хөгжлийн хэлэлцүүлэг цуврал нь Монгол Улсын нотолгоонд суурилсан бодлого боловсруулах үйл явцыг дэмжих үүднээс хөгжлийн гол гол асуудлаар санал солилцох, шинжилгээ судалгааны үр дүнг хуваалцах, олон улсын шилдэг туршлагыг судлах зорилготой.

Энэхүү хэлэлцүүлэгт Монгол Улсын Засгийн газар, олон улсын байгууллагууд, иргэний нийгэм, сургалт судалгааны байгууллагуудын 50 гаруй төлөөлөгчид оролцож Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын биелэлт, тогтвортой хөгжлийн талаар тулгамдаж буй асуудлууд, улмаар 2015 оноос цаашхи хөгжлийн зорилтуудын талаар хэлэлцэн харилцан санал бодлоо солилцлоо.

Хэлэлцүүлгийг нээж НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Эдийн засгийн хөгжлийн яамны удирдлагаас хэлсэн үгэнд дараах асуудлуудыг онцлон тэмдэглэлээ.

- Хөгжлийн асуудлаарх цуврал хэлэлцүүлгийг цаашид уламжлал болгон жил бүр зохион байгуулахаар төлөвлөж буйгаа НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн суурин төлөөлөгч мэдэгдлээ.
- Хэлэлцүүлгийн нээлтийг 2015 оноос хойшхи хөгжлийн зорилтууд сэдвээр хийж буйн учир шалтгаан нь МХЗ-уудын хэрэгжих хугацаа 2015 оноор дуусгавар болж байгаа бөгөөд 2015 оноос хойшхи хөгжлийн зорилтын талаар дэлхий дахинаа аль хэдий нь эхлээд байгаа хэлэлцүүлэгт Монгол Улс хөл нийлүүлэхэд оршиж буй юм. Мөн Монгол Улс дэлхий нийтэд өрнөж буй 2015 оноос хойшхи хөгжлийн зорилтын талаархи хэлэлцүүлэгт ийнхүү чухал хувь нэмэр оруулахын зэрэгцээ өөрийн хөгжлийн замналаа тодорхойлох боломжтой болох юм.
- МХЗ-уудын хэрэгжилтийг дүгнэх хүртэл үлдэж буй 3 жилийн хугацаанд Монгол Улс хэрэгжилтээр хоцрогдолтой байгаа МХЗ-уудын хэрэгжилтийг түргэсгэх талаар олон зүйлийг хийх бололцоо байна. 2015 оноос хойшхи хөгжлийн зорилтуудаа одооноос тодорхойлох нь МХЗ-уудын хэрэгжилтийг хангах ажилтай зөрчилдөхгүй бөгөөд харин ч зэрэг явуулах боломжтой.
- Эдийн засгийн хөгжлийн дэд сайд нээлтийн үгэндээ МХЗ-ууд хэрэгжиж эхэлснээс хойш Монгол Улсын эдийн засаг эрчимтэй өсч эдийн засгийн байдал эрс өөрчлөгдсөн боловч үүнтэй дүйцэх хэмжээний өөрчлөлт нийгмийн салбар болон хүний хөгжилд хараахан бий болоогүй байна. Хөгжлийн хэлэлцүүлгийн нэг гол зорилго нь цаашид энэ байдлыг өөрчилж чадах бодлогыг бий болгоход хувь нэмэр оруулах явдал юм гэж тэмдэглэлээ.

Үүний дараагаар НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Эдийн засгийн хөгжлийн яамнаас дараах илтгэлийг хийлээ.

1) **”2015 оноос хойшхи хөгжлийн зорилтын талаархи хэлэлцүүлгийн танилцуулга”**- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Орлогч суурин төлөөлөгч,

хэлэлцүүлгийг зохион байгуулах НҮБ-ын ажлын хэсгийн ахлагч ноён Томас Эрикссон танилцуулга хийж 2015-оноос хойшхи хөгжлийн зорилтуудын талаар дэлхий дахинаа болон улс орнуудын үндэсний түвшинд өрнөж буй хэлэлцүүлгийн ач холбогдол, үйл явцыг танилцуулж Монгол Улсад эхэлж буй энэхүү хэлэлцүүлэг нь дэлхий дахинаа бий болж буй үйл явдлын нэгэн хэсэг болохыг тэмдэглэлээ.

2) **“2015 оноос хойшхи хөгжлийн чиглэлд тогтвортой хөгжлийн зорилтуудыг тусгах нь”** сэдэвт танилцуулгыг БОНХЯ-ны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга ноён Т. Чулуун хийж “эхлээд хөгжил, дараа нь байгаль орчин” гэдэг уламжлалт хандлага Монгол Улсын болон дэлхий нийтийн 2015 оноос хойшхи хөгжлийн зорилтод байх ёсгүйг онцолж ногоон хөгжлийн зорилтыг 2015 оноос хойшхи хөгжлийн нэг гол зорилт болгохыг уриалав. Мөн доктор Т. Чулуун нь өөрийн зохиосон нэг хүнд ногдох нүүрсхүчлийн хийн ялгаруулалтын үзүүлэлтээр тохируулга хийж тооцсон хүний хөгжлийн индекс (ХХИ)-ийг “Хүний тогтвортой хөгжлийн индекс” болгож болох тухай танилцуулж энэхүү үзүүлэлтээр улс орнуудыг эрэмбэлж үзсэн нь ХХИ-ийн зэрэгцүүлэлтээс хэрхэн өөрчлөгдөж буйг харууллаа.

3) **“2015 оноос хойшхи хөгжлийн зорилтуудад тусгах шаардлагатай Монгол Улсын нэн тулгамдсан асуудлууд”**, сэдэвт танилцуулгыг Эдийн засгийн хөгжлийн дэд сайд ноён О. Чулуунбат хийж орлогын тэгш бус хуваарилалт болон ажилгүйдлийг бууруулах, ногоон хөгжил, тогтвортой хөгжил, нийгмийн хамгааллын боловсронгуй тогтолцоо, бүгдэд хүртээмжтэй эдийн засгийн өсөлт зэрэг нь 2015 оноос хойшхи Монгол Улсын хөгжлийн гол зорилтууд байхыг онцлон тэмдэглэлээ. Мөн 2015 оноос хойшхи дэлхий нийтийн хөгжлийн зорилтууд нь улс орнууд дор бүрдээ болон дэлхий нийтээр тавих зорилтууд гэсэн 2 шатлалтай, хэрэгжилтийг нь хэмжих боломжтой, мөн үйл ажиллагаанд чиглэсэн байх зэрэг шаардлагуудыг биелүүлэх нь зүйтэй талаар санал дэвшүүлээ.

Эдгээр илтгэлүүдийн дараагаар нээлттэй хэлэлцүүлэг явагдсан бөгөөд энэ үеэр яригдсан асуудлуудыг хураангуйлж доор үзүүлээ.

Хөгжлийн ерөнхий асуудлаар:

- Засгийн газрын зүгээс Монгол Улсын хувьд хоцрогдолтой байгаа МХЗ-уудаас гүйцээн хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай арга хэмжээг нээн даруй авах нь чухал байгааг хүлээн зөвшөөрч байна.
- Сүүлийн жилүүдэд гарсан эдийн засгийн өндөр хурдацтай өсөлтийн үр шим иргэн бүрт харилцан адилгүй тусч байгаа. Сүүлийн жилүүдэд 2 оронтой хувиар өсч буй эдийн засгийн өсөлтийн гол үр шимийг хүн амын 10 хүрэхгүй хувь хүртэж, хүн амын 30-40 хувь нь ядуу хэвээр байгаагаас орлогын тэгш бус байдал улам нэмэгдэж байгаа. Хэдийгээр Монгол Улс нь дунд орлоготой орнуудын ангилалд багтах болсон боловч энэ мэт хөгжлийн олон асуудлууд шийдэгдээгүй хэвээр байгаа тул олон улсын хөгжлийн байгууллагуудын тусламж дэмжлэг чухал хэвээр байгаа талаар тус тус тэмдэглэлээ.

- МХЗ-уудын хэрэгжилтээр Монгол Улсын хөгжил дэвшлийг дүгнэх нь чухал төдийгүй 2015 оноос хойшхи хөгжлийн зорилтуудыг томъёолон хэрэгжүүлэхэд анхаарах сургамжуудыг бий болгоход ч ач холбогдолтой юм. Монгол Улсад мянганы хөгжлийн зарим зорилтуудын хэрэгжилт хоцрогдолтой байгаа нь зарим талаар энэ чиглэлээр явуулж буй Засгийн газрын бодлогын ил тод байдал сул, хариуцлагын тогтолцоо бүрхэгтэй холбоотой.
- Олон улсын зах зээл дээр гаргасан Засгийн газрын бондоос бий болсон их хэмжээний санхүүгийн эх үүсвэр нь хүний хөгжлийг шууд дэмжих зорилгоор ашиглагдахгүй гэдэг нь Засгийн газрын албан ёсны байр суурь юм. Гэвч энэ эх үүсвэрээр санхүүжигдэх дэд бүтцийн төслүүд нь ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэхэд зарцуулагдах зэрэг олон сувгаар урт хугацааны туршид шууд бусаар хүний хөгжлийг дэмжих боломжтой.

2015 оноос хойшхи Монгол Улсын хөгжлийн зорилтуудыг тодорхойлох талаар:

- Эдийн засгийн өсөлт нь уул уурхайн салбарт түшиглэж буй эрдэс бүтээгдэхүүнээр баялаг орны хувьд байгаль орчны болон ногоон хөгжлийн зорилтууд нь 2015 оноос хойшхи хөгжлийн асуудалд чухал байр суурь эзлэх ёстой.
- Орлогын тэгш бус хуваарилалтыг бууруулж эдийн засгийн өсөлтийг иргэн бүрт шударгаар хүртээх нь мөн чухал зорилтуудын нэг юм.
- 2015 оноос хойшхи хөгжлийн зорилтууд нь тодорхой, дүгнэх боломжтой байх шаардлагатай бөгөөд дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийг зорилтуудтай хамт тодорхойлох нь зүйтэй.
- 2015 оноос хойшхи хөгжлийн зорилтуудад ашиглагдах үг хэллэг нь энгийн, жирийн иргэдэд ойлгогдохуйц байх шаардлагатай.
- Хэлэлцүүлэг нь жирийн иргэд болон нийгмийн бүлгүүдийн дуу хоолойг нээлттэй сонсох боломжийг бий болгож доороос дээш чиглэсэн байдлаар зохион байгуулагдах нь зүйтэй. Мөн бодлого боловсруулагч болон хэрэгжүүлэгчид жирийн иргэдийн хөгжлийн асуудлаарх санал бодлыг сонсох нь чухал бөгөөд энэ нь ялангуяа орон нутгийн түвшинд зохион байгуулагдах нь илүү ач холбогдолтой юм.
- Байгалийн нөөцөөр баялаг хөгжиж буй орон болох Малайз зэрэг эдийн засгийн нөхцөл байдлаар ижил төстэй орнуудтай хэлэлцүүлэг явуулж хөгжлийн зорилтууд, сайн жишиг, хөгжлийн бодлогын асуудлуудаар санал бодлоо солилцох нь зүйтэй.
- Монгол Улс нь 2015 оноос цаашхи хөгжлийн зорилтын талаарх хэлэлцүүлэгүүдэд идэвхитэй оролцож доктор Т.Чулууны санаачилж буй хүний тогтвортой хөгжлийн индексийг сурталчлах гэх мэт арга хэлбэр байж болох юм.

Ерөнхийд нь дүгнэхэд хэлэлцүүлэгийн үр дүнд Монгол Улсын хувьд 2015 оноос хойшхи хөгжлийн зорилтууд ямар байх талаар тодорхой дүр зураг бий болсон бөгөөд хэлэлцүүлэг нь Монгол Улс энэ талаар дэлхий дахинаа өрнөж буй хэлэлцүүлгийн идэвхитэй оролцогч байх сонирхолтой гэдгийг батлан харуулсан үйл явдал боллоо.

Хэлэлцүүлэгт оролцогчид цаашид ийм төрлийн хэлэлцүүлгийг өргөтгөн хүүхдүүд, залуучууд гэх мэт хүн амын бүлгүүдэд чиглэсэн хэлэлцүүлгүүд, мөн уул уурхайн орлогыг

зохистой ашиглан Монголчуудын хүсч буй ирээдүйг бий болгох нь зэрэг сэдэв дагнасан хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах нь зүйтэй талаар санал нэгдэв.

Дараагийн хэлэлцүүлгийг “Ядуурал Монгол Улсад: Тоо баримтын цаана” сэдвээр 2012 оны 12-р сарын 18-нд зохион явуулахаар төлөвлөсөн болно.